

МОНГОЛ, ИРАНЫ ХАМТАРСАН СУДАЛГААНЫ САН БҮРДҮҮЛЭХЭЭР АЖИЛЛАЖ БАЙНА

Монгол, Иран хоёр Улсын Ерөнхийлөгч нарын 2013 оны уулзалтын үеэр эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хамтран ажиллахаар харилцан тохиролцсон ажлууд амжилттай хэрэгжиж байна. Монгол Улсын Шинжлэх ухааны Академи, Иран улсын Гадаад Хэргийн яамны Олон улсын судалгаа, боловсролын төв хамтран түүх, иргэншлийн судалгааны салбарт хамтран ажиллах тухай 2013 оны “Харилцан ойлголцлын санаамж бичиг”-ийн хүрээнд Монгол, Иран хоёр орны эрдэмтдийн хамтарсан судалгааны үр дүнг нийтэд таниулах зорилгоор Монгол Улсын Гадаад хэргийн яам, ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, Лалын Бүгд Найрамдах Иран Улсын Занжан Их Сургуулийн Ил Хаад судлалын төв хамтран “Иран дахь Ил Хаадын Өв» сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэнг Монголын Үндэсний музейн танхимд энэ оны 10 дугаар сарын 5-ны өдөр нээлт хийж, үзэгчдийн хүртээл болгохоор ажиллав.

Нэн сонирхолтой түүхэн үеийн баримт, эх сурвалжийн каталогийг орчуулан нийтлэх, дижитал номын сан байгуулах, “Судрын чуулган”-ыг эх хэлнээ орчуулан хэвлэх, эрдэм шинжилгээний хамтарсан хуралдааны өгүүлэл, илтгэлийг нийтэлж дэлхий нийтийн хүртээл болгох зэрэг судалгаа шинжилгээний ач холбогдолтой

олон ажлыг 2017-2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Ил хаант улсын түүхээс Рашид Ад Диний “Судрын чуулган” дэлхийн олон оронд хэвлэгдэж, орон орны эрдэмтэд судалж, өөрсдийн санал бодлыг илэрхийлсэн байдаг. Мөн “Ил хаант улсын үеийн шашны хандлага түүний Ази дахь нөлөө” сэдвээр хамтарсан судалгаа гүйцэтгэж, эмхэтгэл хэвлэх, Ил хаадын үе XIII-XIV зууны түүхэн сурвалж, гар бичмэлийн судалгааг гүйцэтгэж, ном сурвалж баримт бичгийн 2200 гаруй жагсаалтыг цуглуулж боловсруулсан байна. Түүнчлэн Монгол, Ираны судлаачид Тегеран, Мараге, Табриз, Занжан хот болон Улаанбаатар хотод ажиллаж, судалгааны ажлын хэсгийн хуралдааныг Тегеран, Улаанбаатар хотноо 2 удаа зохион байгуулж ажиллав. 2015 оны 10 дугаар сард “Гэрэгэ (пайз)” сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулж, 2016 оны 6 дугаар сард “Монгол Ираны харилцаа эрт эдүгээ” сэдэвт үзэсгэлэнг зохион байгууллаа.

Түүнчлэн Рашид-Ад Диний “Судрын чуулган”-ыг ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд бүртгүүлэх ажлыг Ираны талтай хамтран эхлүүлж, Монгол, Ираны хамтарсан судалгааны сан бүрдүүлэхээр ажиллаж байна.

*Монгол улсын Шинжлэх ухааны Академи
“ШУА-ийн Мэдээ” сэтгүүлийн
редакцийн зөвлөл*